


Батлав: Эс Ти Би Эс ХХК-ийн
Захирлын 2024 оны 12 сарын 02 өдрийн
32 тоот тушаалын хавсралт №1



“ЭС ТИ БИ ЭС” ХХК-ИЙН МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл
 - 1.1. Энэхүү журмаар “Эс Ти Би Эс” ХХК-ийн дамжуулах, түгээх болон хэрэглэгчийн сүлжээгээр суваг, урсгалын үйлчилгээ авах болон өгөгдөл дамжуулахын тулд бусад үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээнд холбогдох, барилга байгууламжийн сүлжээнд холбогдох, тэдгээрийг түрээслүүлэх ажилд техникийн нөхцөл олгох, чанарын хяналт тавих, ашиглалтанд хүлээн авахтай холбоотой аливаа харилцааг зохицуулна.
2. Сүлжээнд холбогдох хүсэлт гаргах, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх
 - 2.1. Сүлжээнд холбогдох хүсэлт гаргахдаа хуулийн этгээд бол албан бичиг, иргэн бол хүсэлт байх бөгөөд дараах зүйлсийг хүсэлтэнд заавал тусгана. Үүнд:
 - a) Сүлжээнд холбогдож буй зорилго, хэрэгцээ
 - b) Сүлжээнд холбогдох байршлын албан ёсны хаяг болон байршлын зураг.
 - c) Сүлжээнд холбогдох байршил нь өөрийн эзэмшлийн болон түрээсийнх эсэхийг тодорхойлсон баримт бичиг, түрээсийнх бол түрээслүүлэгчийн зөвшөөрөл.
 - d) Сүлжээнд холбогдох болон өгөгдөл дамжуулах зорилгоор ашиглах шилэн кабелийн шөрмөсийн тоо.
 - 2.2. Хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх
 - 2.2.1. Хүсэлтийг “Эс Ти Би Эс” ХХК компанийн нарийн бичиг хүлээн авч, техникийн комисст хүлээлгэн өгнө.
 - 2.2.2. Техникийн комиссийн инженер хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор техникийн нөхцлийг гаргана.
3. Техникийн нөхцлийн агуулга
 - 3.1. Сүлжээнд холбох боломжтой
 - 3.2. Сүлжээнд холбох боломжгүй
 - 3.3. Техникийн нөхцөл боловсруулах хугацааг сунгах
 - 3.4. Дараах тохиолдолд техникийн нөхцөл боловсруулах хугацааг сунгана. Үүнд:
 - 3.4.1. Шинээр сүлжээ байгуулах трассыг зайлшгүй өөрчлөх нөхцөл үүссэн
 - 3.4.2. Хүсэлт гаргагчтай хамт газар дээр нь тодруулга хийх
 - 3.4.3. Түрээслэгч, түрээслүүлэгч нарын гэрээнд мэдээлэл холбооны сүлжээ ашиглах нөхцөл маргаантай, тодорхойгүй байх
 - 3.4.4. Төрийн эрх бүхий байгууллага шаардсан бол
 - 3.5. Техникийн комисс техникийн нөхцлийг олгох шийдвэр гаргасан тохиолдолд шийдвэрийг нэн даруй баталгаажуулж, хүсэлт гаргагчид мэдээлж, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулна.
 - 3.6. Техникийн нөхцлийг захирал баталгаажуулах ба хоёр хувь үйлдэж, нэг хувийг хүсэлт гаргагчид хүлээлгэн өгнө.
 - 3.7. Техникийн нөхцөл нь 30 хоногийн хүчинтэй байна.
 - 3.8. Техникийн нөхцлийн дагуу сүлжээнд холбогдсон бол гэрээний хүчинтэй хугацааны туршид болон хугацаа дууссанаас хойш 30 хоногийн турш уг техникийн нөхцөл нь хүчинтэй хэвээр байна.
4. Хүсэлт гаргагчийг сүлжээнд холбох
 - 4.1. Техникийн нөхцлийн дагуу сүлжээнд холбогдохыг зөвшөөрч, гэрээ байгуулсан нөхцөлд хүсэлт гаргагчийг сүлжээнд холбоно.

- 4.2. Сүлжээнд холбох хугацаа, сүлжээнд холбогдсонд тооцох хугацааг гэрээнд тусгасан байна.
5. Санхүүгийн нөхцөл
 - 5.1. Сүлжээнд холбогдох техникийн нөхцөл, үйлчилгээний хураамж нь Гүйцэтгэх захирлын баталсан тушаалын үнийн дүнгээр тогтоогдоно.
 - 5.2. Техникийн нөхцөл болон сүлжээнд холбогдох хураамжийг гэрээ байгуулахаас өмнө төлсөн байна.
6. Техникийн нөхцөл олгохоос татгалзах, хүчингүй болгох
 - 6.1. Дараах тохиолдолд техникийн нөхцөл олгох боломжгүй. Үүнд:
 - 6.1.1. Сүлжээний багтаамж дүүрсэн
 - 6.1.2. Дамжуулах сүлжээнд холбогдоогүй
 - 6.1.3. Дамжуулах байгууламж, үндсэн сүлжээнд ноцтой хохирол учруулах эрсдэл үүсэхээр бол
7. Хариуцлага
 - 7.1. Шилэн кабелийг барилга байгууламжид суурилуулахдаа MNS6580 стандартын дагуу суурилуулж, захиалагчтай АКТ үйлдэн хүлээлцэнэ.
 - 7.2. Барилга байгууламжийн үндсэн хийц болон бусад хэсэгт гэмтэл учруулсан бол “Эс Ти Би Эс” ХХК хариуцна. Зайлшгүй шаардлагаар хана болон бусад хэсгийг нүхэлж сүлжээнд холбох тохиолдолд хүсэлт гаргагчид мэдэгдэж, бичгээр зөвшөөрөл авсан байна.
 - 7.3. Сүлжээний үндсэн холболт, төгсгөлийн төхөөрөмжийг гэмтээсэн, зориулалтын бусаар ашигласнаас үүдсэн болон дотоод сүлжээний асуудлыг хүсэлт гаргагч бүрэн хариуцна.
 - 7.4. Шилэн кабелийн ашиглалт үйлчилгээг “Эс Ти Би Эс” ХХК хариуцна.